


Эдийн засгийн огцом өсөлт бий боллоо

2011 оны урьдчилсан гүйцэтгэлээр ДНБ оны үнээр 10,830 тэрбум төгрөг болж, эдийн засгийн өсөлт 17.3%-д хүрэв.


Дэлхийн өндөр хөгжилтэй орнуудын өсөлт буурч байхад энэ нь олон улсын хэмжээнд хамгийн өндөр өсөлт байлаа. Уул уурхайн салбарт түшиглэсэн өсөлт, дэлхийн зах зээл дэх зэсийн өндөр үнэ, нүүрс болон төмрийн хүдрийн экспорт эрс нэмэгдсэн зэрэг нь эдийн засгийн өсөлтийг дагуулж байна.



Улсын төсвийн орлого, зарлага аль аль нь өсч байна

Улсын нэгдсэн төсвийн орлого эхний 2 сарын байдлаар өмнөх оны мөн үетэй харьцуулахад 44.3%, зарлага 45.2% тус тус өсч, тэнцвэржүүлсэн нийт тэнцэл 7.3 тэрбум төгрөгийн алдагдалтай гарлаа.

Төсвийн орлого нэмэгдэхэд дотоодын бараа үйлчилгээний албан татвар 35% өссөн нь хамгийн их нөлөөлсөн бол зарлага өсөхөд татаас ба шилжүүлэг 38% өссөн нь голлон нөлөөлсөн байна.



Импортын өсөлт экспортынхоос 2 дахин хурдлав

Энэ оны эхний 2 сарын байдлаар экспорт өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 27%, импорт 53% өсч, гадаад худалдааны алдагдал 2 дахин нэмэгдлээ.

Экспортын өсөлтөд нүүрс, төмрийн хүдэр, боловсруулаагүй газрын тосны экспортын өсөлт нөлөөлөв. Зэсийн баяжмал, цайрын экспорт буурсан үзүүлэлттэй байна. Импортын өсөлтөд шатахуун, автомашины импортын өсөлт голлон нөлөөлжээ.



Төгрөгийн ханш чангарч эхэллээ

Төгрөгийн ам.доллартай харьцах сарын дундаж ханш өмнөх сараас 3.9%, оны эхнээс 2.4% чангарлаа. Харин өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад 7% суларчээ.

Гадаад валютын нийт албан нөөц өнгөрсөн сараас 1.7% нэмэгдэв.


МБ арилжааны банкуудын саналын дагуу гадаад валютын нийт 7 дуудлага худалдаанд оролцож, 3 удаагийн саналыг биелүүлсэн байна.



Инфляцын жилийн түвшин 12.4%-д хүрчээ

Өмнөх оны мөн үетэй харьцуулахад инфляцын сарын, жилийн болон оны эхнээс тооцсон түвшин өссөн байна.


Инфляцын түвшин өмнөх сараас өсөхөд хүнсний бараа, ундаа, усны үнийн дундаж түвшин 7.2% өссөн нь голлон нөлөөлжээ.



Эх сурвалж: ҮСХ, МБ

Мөнгөний нийлүүлэлт өсч эхэллээ

M2 мөнгө буюу мөнгөний нийлүүлэлт өнгөрсөн сард өмнөх сартай харьцуулахад буурах хандлага ажиглагдаж байсан бол энэ сараас аажим өсөж эхэллээ. Энэ өөрчлөлтөд төгрөгийн хадгаламжийн өсөлт нөлөөлсөн байна. Гүйлгээнд байгаа бэлэн мөнгөний эзлэх хувь мөн нэмэгдэж байна.




Төгрөгийн хадгаламжийн өсөлтийн хурд саарч байна

Нийт хадгаламжийн хэмжээ өмнөх сараас 2.8%, өмнөх оны мөн үеэс 26.7% өссөн байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад төгрөгийн хадгаламжийн өсөлт валютын хадгаламжаас өндөр хэвээр байгаа боловч өсөлтийн хурд нь саарсан хэвээр байна. Төгрөгийн хадгаламж 29.6%, валютын хадгаламж 18.7% өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад өсчээ.



Чанаргүй зээлийн хэмжээ буурах хандлага үргэлжилсээр

Зээлийн өрийн үлдэгдэл өмнөх оны мөн үетэй харьцуулахад 62% өсөж, чанаргүй зээлийн хэмжээ 10.3% буурлаа. Банкны системийн хэмжээгээр чанаргүй зээлийн нийт зээлд эзлэх хувь 5.7% болж, өмнөх оны мөн үеэс 1.8 дахин буурчээ. Гэхдээ олон улсын жишгээр чанаргүй зээл, нийт зээлийн харьцаа 3-аас доош хувьтай байдаг байна.



Эх сурвалж: YCX, МБ

Сарын онцлох үйл явдал

- > Монгол банкны бодлогын хүү өөрчлөлтгүй 12.25% байна.
- > Монгол Улсын ЗГ Олон улсын хөгжлийн ассоциациас Улаанбаатар хотын цэвэр агаар төслийн санхүүжилтэд зориулж 15 сая ам.долларыг 25 жилийн хугацаатай, жилийн 1.25 хувийн хүүтэйгээр авахаар боллоо.
- > Иргэдийг 6% хүүтэй орон сууцны зээлд хамруулах ажил эхэллээ

Хураангуй

Улсын төсөв тэлж, гадаад худалдааны нийт бараа эргэлт нэмэгдсээр байна. Дотоодын бараа үйлчилгээний албан татварын орлого болон татаас ба шилжүүлгийн зардлын өсөлтөөс хамааран төсвийн орлого, зарлага аль аль нь 40 гаруй хувиар нэмэгдээд байна.

Гадаад худалдааны нийт бараа эргэлт 42% өссөн ч импортын өсөлт экспортын өсөлтөөс даруй 2 дахин хурдтай байгаа нь гадаад худалдааны алдагдлыг нэмэгдүүлж байна.

Сар шинийн баярын өмнөх эрэлтийн өсөлт, төсвийн зардлын тэлэлт зэрэг нь үнийн түвшинд нөлөөлж, инфляцийн түвшин 12.4% хүртэл өслөө.

Төгрөгийн ам.доллартай харьцах сарын дундаж ханш энэ сараас эхлэн чангарав. МБ-ны өдрийн албан ханш 1 сарын 10-наас чангарч эхэлсэн ба 2 сарын сүүлээс буцаад сулрах хандлага ажиглагдаж эхэллээ.

Банкны салбарыг тодорхойлогч M2 мөнгө, гүйлгээнд байгаа бэлэн мөнгөний хэмжээ зэрэг үзүүлэлтийн өмнөх оны мөн үетэй харьцуулсан өсөлтийн хурд 1 сард буурах хандлага ажиглагдаж байсан ч энэ сард буцаад өслөө. Энэ нь банкны систем харьцангуй хүчирхэг байгааг харуулж байна. Гэхдээ төсвийн задлын их хэмжээний тэлэлт нь банкны зээл нэмэгдэж буйтай давхцаж байгаа нь төдийлөн зөв хамаарал биш юм.